



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Дундговь аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан



Дундговь аймаг
2016 он

Гарчиг


Өмнөх үг	1
Товчилсон үгийн тайлбар	2
Удирдлага зохион байгуулалт	3
Санхүүгийн тайлангийн аудитын талаар	4
Гүйцэтгэлийн аудитын талаар	6
Нийцлийн аудитын талаар	7
Эрсдэлийн аудитын талаар	8
Дотоод ажлын талаар	10
Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар	13
Дүгнэлт, санал	13

ӨМНӨХ ҮГ

Үндэсний аудитын газрын харьяа Дундговь аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны тайланг та бүхэнд толилуулж байна.

Сонгуулийн тухай хуулинд заасны дагуу орон нутгийн хурлын сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоож, аймаг, сумдын ИТХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшихээр нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн боловсруулсан мөрийн хөтөлбөрт аудит хийж, сонгуулийн зардлын тайланг хянасан, Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын хөгжлийн санаачлагаас зохион байгуулсан хамтарсан гүйцэтгэлийн аудитын хөтөлбөрт аудитын газрын ахлах шинжээч хамрагдаж, олж авсан мэдлэг туршлагаа аудит хийхдээ ашигласан, гүйцэтгэсэн аудитын хүрээнд аудитыг хянан удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын хэмжээнд аудитын төрөл тус бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулсан, Дундговь аймгийн аудитын газарт Монгол Улсын Ерөнхий аудиторын үзлэг шалгалт болон “Чанарын баталгаажуулалтын алба”-наас чанарын хяналт хийгдсэн зэрэг нь энэ тайлант хугацааны онцлог байв.

Үндэсний аудитын газрын харьяа Дундговь аймгийн аудитын газар 2016 онд санхүүгийн тайлангийн болон ҮАГ-ын нэгдсэн удирдамж, аймгийн ИТХ-ын захиалга, өөрийн төлөвлөгөөгөөр хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитуудыг гүйцэтгэхэд хүн хүч, санхүү, цаг хугацааны нөөцийг бүрэн төвлөрүүлж ажиллалаа.



Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гарган, ММНБИ-ийн салбартай хамтран аймгийн хэмжээнд нийт төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудад хууль, эрх зүй болон төсвийн байгууллагын санхүүгийн программ ашиглалтыг нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй хослуулсан сургалтыг зохион байгуулсан, сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах, НБББББ-ийг шинэчлэх, хөрөнгийн тооллого тооцоо, хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулахаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн нь аудитын зөвлөмж үр дүнгээ өгсөн гэж үзэж байна.

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнөөс болон байгууллагаас 2016 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд тодорхой ажлууд хийж, санхүүгийн тайлангийн аудитад СТАУС программыг бүрэн ашиглаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын өгөгдлүүдийг цуглуулах Check list системд мэдээллийг оруулж ажиллаа.

Манай хамт олон хүний нөөцийн мэдлэг, ур чадвар, хариуцлагыг сайжруулах замаар аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, төрийн аудитын байгууллагын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмэрээ оруулахын төлөө зорин ажиллаж байна.

Хүндэтгэсэн

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ОЮУНЧИМЭГ

Товчилсон үгийн тайлбар

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЯ	Сангийн яам
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АЕГ	Архивын ерөнхий газар
АТГ	Авлигатай тэмцэх газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МНБ	Мэргэшсэн нягтлан бодогч
ББНШАЗК	Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
МАХН	Монгол ардын хувьсгалт нам
ИЗНН	Иргэний зориг ногоон нам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАС	Хувийн ашиг сонирхол
ХОМ	Хөрөнгө орлогын мэдүүлэг

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016-12-21

Мандалговь хот.

Нэг. Удирдлага зохион байгуулалт

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнөөс 2016 онд “Аудитын арга зүйн шинэчлэл, мэдээллийн технологийн ололт амжилтыг бататгах, төрийн аудитын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэн, хянан удирдах тогтолцоог сайжруулж, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх”, аймгийн аудитын газраас “боловсон хүчнийг чадваржуулах, хариуцлагыг дээшлүүлэх эв нэгдэл, харилцан биенээ хүндэтгэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, аудитын тайлангийн чанарыг сайжруулах” зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Дээрх зорилтын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, аудитын менежер, аудитор, шинжээч нарын үр дүнгийн гэрээнд тусгуулав.

Тэргүүлэх аудитор Монгол Улсын Ерөнхий аудитортой, аудитын менежер, аудитор, шинжээч нар тэргүүлэх аудитортой үр дүнгийн гэрээ байгуулан, үйлчилгээний ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг жилээр сунган ажиллаж байна.

Байгууллага 2016 онд үндсэн үйл ажиллагаа болон дотоод ажлаар 45 арга хэмжээг төлөвлөснөөс “Улсын төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр олгосон хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт, үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудит Дундговь аймагт хэрэгжсэн арга хэмжээ байхгүй тул хийгдээгүй бөгөөд бусад ажлын хувьд 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аудитын газар тайлант хугацаанд Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу санхүүгийн аудитын багт 4, гүйцэтгэлийн аудитын багт 2, нийцлийн аудитын багт 2 хүний бүрэлдэхүүнтэй, 3 багийн зохион байгуулалтаар нийт 11 орон тоогоор ажиллаж байна. Нийт ажиллагсдын 10 буюу 90.9 хувь нь нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, 5 буюу 50 хувь нь Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч байна.

Тайлангийн хугацаанд байгууллагын хэмжээнд нийт 2534 хүн өдөр 20,272 хүн/цаг ажиллахаас 2777 хүн/өдөр 23,488 хүн/цаг буюу 243 хүн/өдөр 1944 хүн/цаг илүү ажилласан байна.

1.1. Дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийгдсэн ажлын талаар:

Аймгийн аудитын газраас 2016 онд дэвшүүлсэн зорилтыг биелүүлэхийн тулд дараах ажлуудыг хийлээ.

Санхүүгийн тайлангийн аудитыг СТАУС программаар гүйцэтгэж, аудитын үе шатны ажилд чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитор, шинжээч нарт арга зүй, чиглэл өгч ажиллав.

Боловсон хүчнийг чадваржуулах зорилтын хүрээнд байгууллагын санхүүгийн нөөцөд тулгуурлан ажилтнуудыг АОУС, УСНББОУС, СТОУС-ын номоор хангаж, стандартыг бие даан судлан, дотоод сургалт хийж, холбогдох стандартуудыг хялбарчлан ашиглах гарын авлага бэлтгэлээ. Мэргэжлийн тасралтгүй сургалтын хаалтын үеэр аудитор, шинжээч нараас шалгалт авч, гэрчилгээ олгож, төрийн аудитын байгууллагын ажилтнуудаас авах мэргэшлийн шалгалтын шинэ журмын дагуу 2016 оны 12 дугаар сард зохион байгуулсан шалгалтад ахлах аудитор Гантуяа, ахлах шинжээч Д.Ихбаяр нар хамрагдаж, “Онц сайн” үнэлэгдсэн.

Ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор даваа гариг бүрийн шуурхай цуглаанаар ажилтнуудад үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг дүгнэж, ажилтнуудад хариуцлага тооцож ажиллав. Ажилчдын ажлын цаг бүртгэх, нийт ажилласан хоног, цагийг тооцдог excel файл бэлтгэж, ажилтнууд чөлөөг бичгээр авах болсон. Мөн ажлын цаг ашиглалтын журам шинээр боловсруулан 2017 онд мөрдөж эхлэхээр журмын төсөлд ажилтнуудын санал тусгах шатандаа явж байна.

Байгууллагад харилцааны соёлыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд харилцагч нараас ажилтнуудын харилцаа, ёс зүйн талаар санал асуулга авч, дүгнэлт хийн бүх ажилтнуудад сануулга, үүрэг даалгавар өгч ажиллав.

Аудитын чанар үр нөлөөг нэмэгдүүлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор аудитын багуудын дунд 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 4, нийцлийн 6, санхүүгийн тайлангийн 148, эрсдэлийн 3 аудитыг тус тус хийж гүйцэтгэн, төлөвлөгөөнд тусгагдаагүй Сонгуулийн тухай хуулинд заасан 3 ажлыг хэрэгжүүлж, өөрийн санаачилгаар нийцлийн 1, гүйцэтгэлийн 1 аудитыг гүйцэтгэлээ.

Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн тайлангийн аудитаар нийт 39.111.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн.

Тайлант хугацаанд нийт 17.2 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосноос 12.4 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлж, гүйцэтгэл 72.1 хувьтай байна.

Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар нийт 29,155.3 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага өгсний 28,584.3 сая төгрөгийн албан шаардлагыг буюу 98 хувийг харилцагч байгууллага хугацаанд нь хэрэгжүүлж хариу ирүүлжээ.

Аймгийн аудитын газар 2016 оны дүнгээр нийт 33,685.6 сая төгрөгийн үр өгөөж бүртгэж, тайлант хугацаанд 29,119.1 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн 1 төгрөгт ногдох үр өгөөжийг 147.4 төгрөгт хүргэлээ.

Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18.2, 18.3 дахь заалтын дагуу орон нутгийн болон улсын төсвийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, тусгай зориулалтын сангуудын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төвлөрүүлэн захирагчийн 16, төсөл сангийн 3, төсвийн шууд захирагчийн 144, ОНӨААТҮГ-ын 19, нийт 183 байгууллагын санхүүгийн тайлан хамрагдав.

Дээрх байгууллагуудаас Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар 14 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 16 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, нийт 153 дүгнэлт гаргахаар төлөвлөснөөс 148 дүгнэлт гаргасан байна. Дүгнэлт гараагүй 5 байгууллагын хувьд Хүний хөгжил сан, аймгийн Ахмадын хороо гүйлгээ гараагүйгээс, Цагаандэлгэр сумын Эм эргэлтийн сан, Шүүхийн шинжилгээний алба аудитад тайлан материалаа ирүүлээгүйгээс, Дундговь телевиз ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулаагүйгээс санхүүгийн тайлан гаргаагүй гэсэн албан бичиг ирүүлж аудит хийгдээгүй болно.

Аудитад хамрагдсан улсын болон орон нутгийн төсвийн зарим байгууллага, сумдын Эм эргэлтийн сангууд зэрэг нийт 42 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг “Саруул баян уул аудит” ХХК, “Пантер мидланд аудит” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь нийт аудитын 27.5 хувийг эзэлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах нийт байгууллагад аудитын захидал хүргүүлж, санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэв. Аудитад СТАУС программыг бүрэн ашиглаж, аудитын үе шат бүрд чанарын хяналтыг хэрэгжүүлэхэд үр дүн гарлаа.

Аудитад зарцуулсан хүн.өдөр 1064, аудитын өртөг 64.0 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 1,884.1 сая төгрөг.



Санхүүгийн тайлангийн аудитад АДБОУС, АОУС-ыг мөрдөж, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврыг шалгуур болгон ашиглав.

Аудит хийлгэсэн байгууллагын “Санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн

өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайланг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэхэд дүгнэлт гаргах"-ийн тулд санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж, нотолгоонд тулгуурлан дүгнэлт өглөө.

Аудитаар нийт **148** байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс **119** байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, **24** байгууллагад “Хязгаарлалттай”, **3** байгууллагад “Сөрөг”, **2** байгууллагад “санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт гаргасан байна.

Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн аудитын дүгнэлтийг УАГ-ын Санхүүгийн аудитын газарт болон үйлчлүүлэгч байгууллагуудын төсөв захирагч нарт хуулийн хугацаанд хүргүүлсэн. Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд 2016 оны 04 дүгээр сарын 08-19-ны хооронд аудитыг хийж, аудитын дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагчид болон УАГ-ын Санхүүгийн аудитын газарт хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **7,331.9** сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, аудитын явцад **74** хувь буюу **5,423.6** сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж ТЭЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгүүлсэн.

Аудитын явцад төсвийг зориулалт бусаар зарцуулсан, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийгээгүй, чанаргүй, дутуу хийж тооцоог бодож баталгаажуулаагүй, шатахууны тооцоог бодож, баталгаажуулдаггүй, гадны тээврийн хэрэгсэлд шатахуун олгохдоо гэрээ байгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн, урамшууллыг журамд заасан хэмжээнээс илүү олгосон, хүчингүй болсон зэргийн үнэмлэхээр зэргийн нэмэгдэл олгосон, эм бэлдмэлийг орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан, тусгай зориулалтын сангуудын барьцаа хөрөнгийг орлогоор бүртгэсэн, сум хөгжүүлэх сангийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, орлого, зардлын зүйлийг буруу тайлагнаж, дансны бичилтийг буруу хийсэн, орон нутгийн орлогын төлөвлөгөө биелүүлээгүй, өглөг, авлагыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан зэрэг нийтлэг алдаа, зөрчил илэрч байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн нийт зөрчлийн **74.5** хувь нь бүртгэл тайлагналын алдаа болон хууль эрх зүйн заалтыг зөрчсөн тушаал шийдвэр гаргасантай холбоотой зөрчлүүд байгаа нь төсвийн байгууллагын менежер, нягтлан бодогч нарын хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чадвар дутмаг, санхүүгийн сахилга бат, дотоод хяналт хангалтгүйтэй холбоотой байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар **1,885.9** сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай **106** албан шаардлага өгч, хохирлыг нөхөн төлүүлэхээр **10.1** сая төгрөгийн **21** төлбөрийн акт тогтоолоо.

Санхүүгийн аудитын үйлчилгээний төлбөрт гэрээний дагуу **1.1** сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **1895.5** сая төгрөгийн **131** үр өгөөж бүртгэснээс тайлант хугацаанд **1,884.1** сая төгрөгийн **121** үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитын үеэр ажилдаа хариуцлагагүй хандсан, санхүүгийн дотоод хяналтыг бүрдүүлж ажиллаагүй, аудитын хугацаа хоцроосон, зэрэг зөрчил гаргасан, “Хязгаарлалттай” болон “Сөрөг” санал дүгнэлт авсан төсвийн шууд захирагч, санхүүгийн ажилтан нийт **58** албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлагыг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсний **53-г** нь хэрэгжүүлж хариуг албан тоотоор ирүүлсэн.

Улсын болон орон нутгийн төсвийн зарим байгууллага, ОНӨААТҮГ-ууд зэрэг **45** байгууллагын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Саруул баян уул аудит” ХХК, “Их наяд аудит” ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан, ажлын даалгавар хүргүүлсэн. Мөн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Их наяд аудит” ХХК-д хуваарилсан **9** байгууллагаас **8** байгууллагын төлөвлөлтийн үе шатны ажилд чанарын хяналт хийгээд байна.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

ҮАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу 2016 онд 4, өөрийн төлөвлөгөөний дагуу 1 гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөснийг бүрэн гүйцэтгэж, орон нутгийн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулан аймгийн ИТХ-д хүргүүлээ.

Аудитаар нийт **26,982.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, **22,509.7** сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага **31**-ийг хүргүүлж, 100 хувийн хэрэгжилттэй байна. Гүйцэтгэлийн аудитаас нийт 26,983.0 сая төгрөгийн 52 санхүүгийн үр өгөөж бүртгэж, тайлангийн хугацаанд 22,997.1 сая төгрөгийн 37 үр өгөөжийг тооцсон нь 85.2 хувийн хэрэгжилттэй байна.

Аудитад зарцуулсан хүн.цаг 4456, аудитын өртөг 53.2 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн аудитын үр өгөөж 22,997.1 сая төгрөг.

Аудитын дүнг шалгадагч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан бусад холбогдох албан тушаалтанд танилцуулан аудитын тайланг тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан ҮАГ-т хүргүүлээ.

2016 онд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнгээс товч танилцуулбал:

3.1 “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж аудитын нотлох баримтанд үндэслэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн боловч зарим ажлын гүйцэтгэл дутуу, бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн боловч зарим ажлууд дутуу хийгдсэн, их засварын ажлын гүйцэтгэлд тавих зохиогчийн хяналтыг тухай бүр хийгээгүй, төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй зөрчил илэрсэн. Харин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хувьд хөрөнгийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийг зөрчиж баталсан, эрх шилжсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлүүд илэрсэн. Эдгээр нь холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийг стандарт журмын дагуу хөтөлдөггүй, зураг төслийг захиалагч талтай тохиролцон өөрчлөн гүйцэтгэдэг боловч гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулдаггүй зэргээс шалтгаалсан байна. Аудитаар нийт 26,778.1 сая төгрөгийн зөрчил илрүүлсний 20,142.3 сая төгрөг буюу 75.2 хувь нь бүртгэл, тайлагналтай, 150.0 сая төгрөг буюу 0.6 хувь нь худалдан авалттай, 6,485.8 сая төгрөг буюу 24.2 хувийг хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил эзэлж байна.

3.2 “Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д аудит хийж “Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь давуулан биелүүлж, нэр төрлөөр 5 орлого тасарсан байна.” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв. Аудитаар орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй, тооцоо судалгаагүй өндөр баталдаг, зарим сумдад орлогын ногдуулалтыг бүрэн хийдэггүй, орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлдэггүй зэрэг алдаа зөрчлүүд илэрсэн. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь давуулан биелүүлсэн ч 5 нэр төрлийн орлогыг 158.7 сая төгрөгөөр тасарсан байна. Орлогыг бодитой төлөвлөх, төлөвлөгөөг биелүүлэхэд санаачилгатай ажиллах, хяналтыг сайжруулах зөвлөмжийг ТЕЗ-д өгөв.

3.3 “Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитад “Төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамрагдах мэдээлэлтэй танилцах, аудит хийх, нууцах” журмыг мөрдөж ажиллав. Аудитаар өмнөх оны өвсний үлдэгдэлд чанарын шинжилгээ хийлгээгүй, Эрдэнэдалай сумын улсын нөөцийн агуулахын байранд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулаагүй зэрэг нийт 45.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Тус аудитаар Говь-Угтаал, Эрдэнэдалай сумдад ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

талаар холбогдох албан тушаалтанд зөвлөмж өгч, үр өгөөжийг бүртгэж тооцоо, судлагааг маягтын дагуу гаргаж нэгтгүүлэв.

3.4 “Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл”-д гүйцэтгэлийн аудит хийж “Улсын Их Хурал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн чиглэлийн дагуу зарцуулжээ.” гэсэн дүгнэлт өгсөн. Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороод болон аймгийн Улсын бүртгэл, статистикийн газар, аймгийн Цагдаагийн газарт сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлийг хамруулсан.

Аудитын дүнд Сонгуулийн ерөнхий хороонд уламжлуулахаар ҮАГ-т 4 заалт бүхий саналыг хүргүүлсэн.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар

Тайлант хугацаанд ҮАГ-ын нэгдсэн удирдамж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу 6 нийцлийн аудит хийхээр төлөвлөснийг бүрэн гүйцэтгэлээ.

Аудитад зарцуулсан хүн.цаг 3961, аудитын өртөг 55.1 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн аудитын үр өгөөж 3,009.7 сая төгрөг.

Нийцлийн аудитаар нийт **3,041.2** сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр **4.0** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **3,037.2** сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлээд байна.

2016 онд хийсэн нийцлийн аудитын дүнгийн талаар товч танилцуулбал:

4.1 “Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт, зарцуулалт” хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажил нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн боловч хөрөнгийн зарцуулалт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй хэвээр байна.” гэсэн дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 2,533.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 4.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,529.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнээс 1,777.6 сая төгрөгийн зөрчил буюу 70.2 хувийг нь аудитын явцад залруулсан болно.

Аймаг, сумдын Засаг дарга нарт болон Засаг даргын Тамгын газрын дарга нарт 16 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

4.2 “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д эхний хагас жил болон 3 дугаар улирлын байдлаар 2 удаа нийцлийн аудит хийж “Шилэн дансны тухай хуулийн зарим заалтын хэрэгжилт, түүнд тавих хяналт хангалтгүй байна.” гэсэн дүгнэлт өглөө.

Эхний хагас жилийн аудитаар нийт 367.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, хугацаатай албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг албан бичгээр хүлээн аваад байна.

3 дугаар улирлаар тасалбар болгон хийсэн аудитаар нийт 31.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж холбогдох байгууллагад хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Мөн Дэрэн сумын “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дарга өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Аудитаар хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг оруулаагүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн. 2 удаагийн аудитын дүнгээр аймаг, сумдын ИТХ, иргэдийн Нийтийн Хурал, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хуулинд заасан хяналтын үүргээ хэрэгжүүлээгүй байлаа.

4.3 “Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын хувьд манай аймагт “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”, “Байгаль хамгаалах сан”-гийн үйл ажиллагааг хамруулсан.

“Байгаль хамгаалах сангийн зарцуулалтын байдал”-д хийсэн нийцлийн аудитаар 98.0 сая төгрөгийг зөрчил илрүүлж, “Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг бодитой төлөвлөн, зарцуулалтыг олон нийтэд мэдээлэх шаардлагатай байна” гэж дүгнэсэн.

“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитын дүнд үндэслэн “Суралцагчид олгох тэтгэлгийг ирцээс гадна бусад үзүүлэлттэй уялдуулах шаардлагатай байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн. Тус аудитаар 0.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар холбогдох албан тушаалтнуудад хугацаатай албан шаардлага өгч, зөвлөмжийг тайлангаар хүргүүлээ.

4.4 “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн “Байгаль орчныг хамгаалах тухай хуулиёй хэрэгжилт çàðåì òàëààä òàì ààëäçé байна.” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн. Аудитаар нийт 114.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 9.7 сая төгрөгийн çò÷ëëéã арилгуулахаар хугацаатай албан шаардлага òçäãçéæ, 104.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

4.5 “Орон нутгийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл”-д нийцлийн аудит хийж, “Аймгийн хэмжээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлыг хууль, журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна.” гэж дүгнэлээ. Тус аудитаар сонгуулийн хэсгийн хороонд бүртгэлтэй иргэдийн тоо, санал өгсөн иргэдийн тоо харилцан адилгүй байгаа нь сумын ИТХ-ын сонгуульд сонгогчдын ирц буурсантай холбоотой бөгөөд сонгуулийг жилд 2 удаа зохион байгуулах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй тул цаашид аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг хамтатган явуулах нөхцөлийг судлан, эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх саналыг СЕХ-нд уламжлуулахаар ҮАГ-т хүргүүлсэн.

Тав. Өөрийн төлөвлөгөөт аудитын талаар

Байгууллагын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Халамжийн сангийн төлөвлөлт, зарцуулалт”-д 2015-2016 он дамжуулан нийцлийн аудит хийж, “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт”-д гүйцэтгэлийн аудит, “Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, үр дүн”-д нийцлийн аудит, Сайнцагаан сумын гуравдугаар цэцэрлэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Дэрэн сумын Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2015 он, 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийлээ.

2016 онд өөрийн төлөвлөгөөгөөр хийсэн аудитын дүнгийн талаар товч танилцуулбал:

Эрсдэлийн аудитаар хөрөнгийн түүвэр хяналтын тооллого хийх, тулган баталгаажуулах, түүврийн сорил гүйцэтгэх, санхүүгийн тайлангаас НББ-ийн журнал руу, журналаас анхан шатны баримт руу хөөн шалгах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан холбогдох горимууд хэрэгжүүлээ.

Эрсдэлийн аудитаар нийт **889.1** сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, **858.8** сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн

5.1 “Сайнцагаан сумын гуравдугаар цэцэрлэг”-ийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийж “Санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.” гэсэн дүгнэлт өглөө. Аудитаар нийт 6.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 0.8 сая ò°ãðäëéí òòàäòààäàë äëààì ø ààääëàãыг хүргүүлж, 7 заалт бүхий зөвлөмж өгч ажиллалаа. Бараа материалын зарцуулалт, үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналт хангалтгүй, авлага өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлд

5.2 Дэрэн сумын “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2015 он, 2016 оны I дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд стандарт, хууль журам мөрдөөгүй, хяналт, санхүүгийн сахилга алдагдсан байна.” гэсэн дүгнэлт өглөө. А᠋᠎ᠠᠭᠡᠳᠠᠰᠢ ᠶᠤᠨ 529.2 сая ᠔° ᠗᠐' ᠗᠙" c ᠔-᠑᠓᠑᠘ ᠑᠓; ;᠑ᠭ, ᠒᠔᠕᠐᠕᠔᠔᠖ ᠗᠙᠕᠕ ᠐ ᠕᠔᠗᠙᠕᠕ ᠔; ᠔᠗; ;᠑ᠯᠡ.

5.3 “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийж, “Сангийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн, авлагыг баталгаажуулаагүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн. Аудитаар нийт 363.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 332.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, 31.1 сая төгрөгийн зөрчилд засаж сайжруулах 5 заалт бүхий зөвлөмж өглөө.

5.4 “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт”-д гүйцэтгэлийн аудит хийж, “Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин бүрдээгүй байна.” гэж дүгнэлээ. Энэ аудитад Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын хөгжлийн санаачлагаас өгсөн арга зүй болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашигласан, тайланд олон улсын туршлага болон сумдын туршлагаудыг оруулсан нь онцлог байлаа.

5.5 “Халамжийн сангийн төлөвлөлт, зарцуулалт”-д хийх нийцлийн аудитыг цаг үеийн ажлын шаардлагаар тэргүүлэх аудиторын тушаалаар хөтөлбөрт өөрчлөлт оруулан аудитыг он дамжин гүйцэтгэсэн. Тус аудитаар анхан шатны баримттай тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, Халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмж авагч иргэдээс сонгож уулзан санал авах, судалгаа хийх зэрэг аудитын арга зүй горимууд хэрэгжүүлэв. Аудитаар нийт 2.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 0.8 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 1.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага, 10 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн мэдээ тайлан, үр өгөөжийг бүртгэж тайлагнасан.

5.6 “Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, үр дүн”-д нийцлийн аудит хийж, “Төсөл сонгон шалгаруулалт оновчгүй, сангаас олгосон зээлийн гэрээний биелэлт, төслийн үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.” гэж дүгнэлээ. Аудитаар нийт 863.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 861.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага, аймаг, сумдын Засаг дарга нарт 10 заалт, Хүнс, хөдөө аж ахуйн газарт 4 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт тооцох хугацаа хараахан болоогүй байна.

5.7 Орон нутгийн 2017 оны төсвийн төсөл болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх, талаар санал боловсруулан 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хуралдсан

аймгийн ИТХ-д танилцуулав. Дундговь аймгийн 2017 оны төсвийн төсөлд хог, хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 2017 оны төсөвт өмнөх оны түвшингээс бууруулахгүйгээр 51.7 сая төгрөгөөр төлөвлөх, газрын төлбөрийг бүрэн ногдуулж, төсөвт төвлөрүүлэх, цаашид анхаарах асуудлуудын талаар болон төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах 3 санал өглөө.

Бусад ажлын талаар

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь заалтыг үндэслэн, ҮАГ-с тогтоосон жишигт нийцүүлэн аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн тойрогт нам, эвсэл тус бүрийн зарцуулах зардлын дээд хэмжээг 143.0 сая, нэр дэвшигчийн зарцуулах зардлын дээд хэмжээг тойрог тус бүрээр 8.9-12.1 сая төгрөгийн хооронд тогтоов. Зардлын дээд хэмжээ тогтоосон тухай 2016 оны 3 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээллээ.
2. Сумын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, эвсэл тус бүрийн зарцуулах зардлын дээд хэмжээг 61.0 сая, нэр дэвшигчийн зарцуулах зардлын дээд хэмжээг тойрог тус бүрээр 4.0-16.0 сая төгрөгийн хооронд тогтоов. Зардлын дээд хэмжээ тогтоосон тухай 2016 оны 7 дугаар сарын 18-ны өдөр олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээллээ.
3. Аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвшихээр ирүүлсэн 5 нам, 16 бие даан нэр дэвшигчийн боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөрт туссан зорилт арга хэмжээ нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргалаа. Нам, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 4 дүгээр сарын 29-ны өдөр хүртэлх хугацаанд дүгнэлт гаргаж, аймгийн Сонгуулийн хороонд хугацаанд нь хүргүүлээ. Нийт 21 дүгнэлт гаргаснаас нийцсэн 20, нийцээгүй 1 /ИЗНН/ дүгнэлт өгөв. Аудитын явцад 3 нам, 2 бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4 дэх заалттай зөрчилдсөн тул нийт 7 заалт бүхий 5 албан шаардлага хүргүүлж, мөрийн хөтөлбөрт залруулга хийлгэсэн.
4. Сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн нийт 42 мөрийн хөтөлбөрт аудит хийж дүгнэлт гаргасан. Үүнд:
 - а. Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Гурвансайхан, Өндөршил, Өлзийт, Хулд, Луус, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Адаацаг, Сайнцагаан зэрэг 15 сумдын Монгол ардын намын хороодын мөрийн хөтөлбөр,
 - б. Сайнцагаан сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр,
 - в. Бие даан нэр дэвшихээр 25 иргэний ирүүлсэн мөрийн хөтөлбөр,
 - д. Монгол ардын хувьсгалт намын нэгдсэн мөрийн хөтөлбөрт тус тус дүгнэлт гаргав.Дундговь аймгийн Ардчилсан намын 2016 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн 81 тоот албан бичгээр Сайнцагаан сумаас бусад 14 сумдад аймгийн мөрийн хөтөлбөрөөр оролцох, Монгол ардын хувьсгалт намын 2016 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 01/75 тоот албан бичгээр бүх сумдад нэгдсэн нэг мөрийн хөтөлбөрөөр орон нутгийн сонгуульд оролцох болсноо тус тус мэдэгдсэн болно.
5. Монгол Улсын Ерөнхий аудиторовн үзлэг болон Чанарын баталгаажуулалтын албаны чанарын хяналтад хамрагдан өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зургаа. Дотоод ажлын талаар

Тайлант онд 526 албан бичгийг хүлээн авч бүртгэн, хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 350 албан бичгийг холбогдох байгууллагад явууллаа. ҮАГ-аас 50 албан бичгийг хүлээн авч, бүртгэн холбогдох хүмүүст үүрэг өгч шилжүүлсэн.

Энэ тайлант хугацаанд акт 35, албан шаардлага 189, тэргүүлэх аудиторовн А дугаар тушаал 39, Б тушаал 11 гарсан байна. Аймгийн аудитын газрын баримт бичиг хадгалах хугацааны

- Шинжээч Д.Должинсүрэн Улаанбаатар хотод АЕГ-ийн сургалтын төвөөс 2016 оны 12-р сарын 12-14-ны өдрүүдэд зохион байгуулсан 4 өдрийн сургалтад хамрагдав.
- Аудитор Х.Гарам Мэргэшсэн нягтлан бодогчийн институтээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах сургалтанд хамрагдаж шалгалтаа амжилттай өглөө.
- ҮАГ-с 7-р сард зохион байгуулсан аудитад мэдээлийн технологийг ашиглах хөгжүүлэхэд ТАБ-ын төв болон орон нутгийн байгууллагуудын аудиторчуудын дунд зохион байгуулсан /СТАУС програмын хөгжүүлэлтийн талаарх/ хэлэлцүүлэгт шинжээч Ч.Бэрхсайхан, шинжээч Ж.Угтахбаяр, аудитор Т.Оюун-Эрдэнэ нар оролцов.
- Ажилтнууд Улаанбаатар хотод Нийслэлийн аудитын газарт туршлага судлан ажлын байрны сургалтад хамрагдав.
- Шинжээч С.Жалбаа, Д.Должинсүрэн нар ММНБИ-с зохион байгуулсан МНБ-ийн эрх олгох сургалтанд хамрагдаж, мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалт өгснөөр англи хэл, аудит, хуулийн шалгалтанд тэнцсэн.



- Бүх ажилтнууд Дархан, Сэлэнгэ аймгийн Аудитын газруудад туршлага судлаж, ОХУ-ын Улан үдэ хоттой танилцан, Итгэлт хамбад мөргөж, Байгаль нуурт аялан алжаалаа тайллаа.

- Ажилтнуудыг 2016 оны 6 дугаар сарын 07-ны өдөр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулав.

- Аймгийн ЭМГ-т ажилтнуудын биеийн хөгжлийн үзүүлэлтүүдийн үнэлгээ хийлгэв.

- Ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор даваа гариг бүр 2 цаг сагсан бөмбөг, гар бөмбөгийн спортоор хичээллэж байна.

- Ажилтнуудын ажиллах нөхцөлөөр хангах, нийгмийн асуудалд дэмжлэг болох зорилгоор ажилчдын орон сууц барихад зориулан газрын асуудлыг шийдвэрлүүллээ. /Засаг даргын 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/269 дугаар захирамж/
- Мөн ХААН банктэй хамтарч ажиллах гэрээ байгуулж, ажиллагсдын цалингийн зээлийн хүүг бууруулж, тус банканд мөрдөх хамгийн бага хувиар олгохоор шийдвэрлүүллээ.

Ахмад настнаа дээдлэх зорилгоор ахмадын баяр болон цагаан сараар байгууллагын харьяа ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлж, 8 дугаар сард 5 ахмадыг сувилалд амраалаа.

ММНБИ-ийн 20 жилийн ойг Дундговь аймаг дахь салбартай хамтран орон нутагт тэмдэглэн өнгөрүүлээ.

Тус ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй баг түрүүлж алтан медаль, эмэгтэйчүүдийн хамтарсан баг 2 дугаар байранд шалгарч мөнгөн медаль хүртлээ. Мөн аймгийн хэмжээнд “Бүртгэл санхүүгийн ажилтны баяр”-т зориулсан гар бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцож, эмэгтэй, эрэгтэй багууд тус бүр мөнгөн медаль хүртэж, багийн дүнгээр 2-р байр эзлэн, теннисээр хүрэл медаль хүртэв.

Дундговь аймаг байгуулагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан ажилтнуудын ажлын амжилтыг үнэлж ахлах шинжээч Д.Ихбаярт ҮАГ-ын хүндэт өргөмжлөл, аудитын менежер Б.Гантуяа Төрийн албаны тэргүүний ажилтнаар тус тус шагнагдсан.

Аймгаас зохион байгуулсан олон нийтийн ажилд хамт олноороо идэвхитэй оролцож, орчны хог, цас цэвэрлэн, өвөлжилтийн бэлтгэл хангахад зориулан халтар хомоол түүж Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өглөө.



Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар

Санхүүгийн тайланг улирал, хагас жилээр хуулийн хугацаанд гаргаж, төсвийн зарцуулалтын тайлан мэдээг сар бүр гаргаж ҮАГ-т хүргүүлсэн.

Төрийн өмчийн улсын үзлэг тооллоготой холбогдуулан тооллогын комисс томилж, байгууллагын хөрөнгийн тооллого хийж үр дүнг тооцож ажиллав.

ӨХБЗ-өөс дүгнэлт гарсан акталж устгах хөрөнгийн шийдвэр гаргуулахаар холбогдох материалыг ҮАГ болон СЯ-ны Төрийн өмчийн удирдлага, тооллого хяналтын газарт хүргүүлэв.

Байгууллагын 2013-2015 онуудын төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсвийн төсөл, 2018, 2019 оны төсвийн төсөөллийг хийж гүйцэтгэн холбогдох газарт хүргүүлсэн.

Аудитын газар 2016 онд 197.8 сая төгрөгийн төсөв батлагдан, гүйцэтгэлээр 197.5 сая төгрөгийг холбогдох зардалд зориулалтын дагуу зарцуулав. Мэдээллийн ил тод байдлыг хангаж төсвийн гүйцэтгэлийн мэдээг ханын самбарт мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг shilendans.gov.mn сайтад сар бүр цаг хугацаанд нь байршуулж ажилласан.

Найм. Дүгнэлт, санал

Тайлант хугацаанд үйл ажиллагаандаа АДБОУС, Аудитын Олон улсын стандартыг мөрдөн, Төрийн аудитын тухай хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх, төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байх үндсэн зарчмуудыг баримтлан, ёс зүйн хэм хэмжээг сахиж, сонирхлын зөрчилгүй ажилласан.

Манай хамт олон санхүүгийн тайлан баталгаажуулах аудит хийх цаглабарт хугацаанд, ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэл, нийцлийн 4 аудитыг зэрэгцүүлэн гүйцэтгэж, мөн сонгуулийн тухай хуульд заасан үүрэгт ажлуудыг хэрэгжүүлэн ачаалалтай ажилласан ч 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг 100 хувь гүйцэтгэсэн.

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, аймгийн Аудитын газраас дэвшүүлсэн зорилтыг биелүүлэхийн тулд тодорхой ажлууд хийж үр дүнд хүрлээ.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүн зөвлөмжид ихээхэн ач холбогдол өгч, аймгийн хэмжээнд нийт төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудаас түвшин тогтоох шалгалт авч, шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан ажилтнуудад сургалт зохион байгуулсан нь аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хийх үр дүнтэй ажил боллоо.

Санал:

- ❖ Нэгдмэл удирдлагатай байгууллага болохын хувьд аудитыг ижил түвшинд хийх, аудитын сэдэвтэй холбоотой болон илэрч байгаа зөрчил дутагдлын талаар мэдээллээ харилцан солилцох, аймаг орон нутгийг холбож ажиллах;
- ❖ Орон нутгийн аудитын газарт орон тоо нэмэх, боломжгүй бол гэрээт ажиллагсдын зардлын төсвийг нэмэгдүүлэх;
- ❖ Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэж байгаа аудитын төлөвлөлтийн өмнөх, төлөвлөлт, тайлагналын дараах үе шатны ажил хэрэгжүүлэх цаг хугацааг орон нутагт хангалттай тавьж өгөх;
- ❖ Татвар, Нийгмийн даатгал зэрэг төсвийн орлого бүрдүүлдэг агентлагуудтай мэдээлэл солилцох, цахимаар мэдээлэл авах боломжийг судлан, ҮАГ нэгдсэн журмаар зохицуулах нь аудитад шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй хурдан шуурхай авах нөхцөл бүрдэж, ингэснээр аудитын чанар үр өгөөж нэмэгдэх боломжтой.

ТӨРИЙН МЭЛМИЙ ХУРЦ, ТУНГАЛАГ,
ТҮМЭН ОЛОН АМГАЛАН БАЙГ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР